



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/56

Улаан-Уул

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2022 оны А/247 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Комиссын дарга Г.Баттогтох-Засаг даргын орлогч

Гишүүдэд: С.Хонгорзул – Санхүү албаны дарга

Ц.Эрдэнэчимэг-Улсын бүртгэгч

Г.Баасанжаргал-Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан ажилтан

Нарийн бичгийн дарга Д.Сайханцэцэг-Санхүү төрийн сангийн мэргэжилтэн

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 64 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах журам”, мөн тус тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын үр дүнгийн маягт, хүснэгтийг ашиглах заавар”, холбогдох байгууллага албан тушаалтанаас ирүүлсэн зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг комисс /Г.Баттогтох/-д даалгасугай.

3. Байгууллага тус бүрд тооллогын комисс томилж, эд хөрөнгө нэг бүрийг нүд үзэж тоолох, тооллогын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор дуусгахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажилд санаатай болон санамсаргүй байдлаар саад учруулсан, холбогдох мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан, хариуцсан эд хөрөнгийг дутагдуулсан зэрэг

642201091

зөрчлийг цаг тухайд нь мэдэгдэж, хариу арга хэмжээ авч ажиллахыг комиссын дарга, нарийн бичгийн дарга нарт даалгасугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ

